

НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ОЛГОХ ТЭТГЭМЖ

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ **36 сараас** доошгүй хугацаанд төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барвал түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно.



Мөн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байсан иргэн нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно.

Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээ **2.000.000** төгрөг бөгөөд хэрэв нас барсан даатгуулагч амьгүй донор болж эс, эд эрхтнээ бусдад шилжүүлсэн бол гэр бүлийн гишүүнд нь **3.500.000** төгрөгийн тэтгэмжийг нэг удаа олгоно.

Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэслэл зөвлөл тогтооно.



Жишээ:

Даатгуулагч 16 жил 5 сар ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлж байгаад 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс ажлаас чөлөөлөгдсөн гэвэл:

Шимтгэл төлсөн сүүлийн 3 сар	Цалин, хөлс түүнтэй адилтгах орлого (төгрөгөөр)
1	1.700.000
2	1.850.000
3	1.870.000

- а. Сарын дундаж цалин: **1.806.700 ₮**
(1.700.000+1.850.000+1.870.000) : 3 сар
- б. Нэг сард ногдох тэтгэмж: **1.264.690 ₮**
1.806.700 * 70% (16 жил 5 сард ногдох)
- в. Ажлын нэг өдөрт ногдох тэтгэмж: **60.223 ₮**
1.264.690 ₮ : 21 өдөр (сарын дундаж хоног)
- г. Олговол зохих тэтгэмж:
60.223 ₮ * 76 өдөр = 4.576.948 ₮



**АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ ОЛГОЛТЫГ
ЗОГСООХ ҮНДЭСЛЭЛ**

Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж албан журмаар шимтгэл төлж эхэлсэн

Өндөр насны эсхүл хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон

Үндэслэлгүйгээр ажилгүйдлийн тэтгэмж авч байсан нь тогтоогдсон

Цэргийн жинхэнэ албыг биеэр хаахаар татагдсан

Хорих ял эдлүүлэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон

Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа нас барсан

ᠨᠢᠶᠭᠮᠢᠨ ᠳᠠᠭᠲᠠᠭᠠᠯ ᠰᠤᠨᠭᠠᠭᠠᠳ ᠣᠯᠭ᠎ᠠ

ҮӨМШӨ-НИЙ ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагч нас барсан тохиолдолд түүний асрамжид байсан гэр бүлийн **хөдөлмөрийн чадваргүй гишүүд** нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгоно.



ТЭЖЭЭГЧИЙН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГООС

1 гишүүнтэй бол
50 хувь

2 гишүүнтэй бол
75 хувь

3 ба түүнээс дээш
гишүүнтэй бол 100 хувь

Жишээ:

Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 1 жил төлж байгаад үйлдвэрлэлийн ослын улмаас нас барсан. Түүний ар гэрт хөдөлмөрийн чадваргүй 2 хүүхэд үлдсэн бөгөөд сард **1.500.000** төгрөгийн цалинтай байсан гэвэл: - Сард олговол зохих тэтгэвэр:

$$1.500.000\text{₮} * 75\% (2 \text{ хүүхдэд ногдох хувь}) = 1.125.000\text{₮}$$

ᠨᠢᠶᠭᠮᠢᠨ ᠳᠠᠭᠲᠠᠭᠠᠯ ᠰᠤᠨᠭᠠᠭᠠᠳ ᠣᠯᠭ᠎ᠠ ᠬᠥᠳᠡᠯᠮᠥᠷᠢᠨ ᠴᠠᠳᠪᠠᠷ ᠲᠦᠷ ᠠᠯᠳᠤᠰᠠᠨᠢ ᠲᠡᠳᠲᠦᠮᠵᠢ

ҮӨМШӨ-НИЙ ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй. Ингэхдээ шимтгэл төлж ажилласан хугацааг үл харгалзан даатгуулагчийн сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 100 хувиар тооцож, ажлын өдрөөр бодож олгоно.

**ДААТГУУЛАГЧИЙН ТЭТГЭМЖ БОДОХ САРЫН ДУНДАЖ ЦАЛИН ХӨЛС,
ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ**

3 сар ба түүнээс дээш хугацаанд шимтгэл төлж ажилласан бол



Хөдөлмөрийн чадвар түр алдахын өмнөх 3 сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг 3-т хувааж

3 сараас доош хугацаанд шимтгэл төлж ажилласан бол



Хөдөлмөрийн чадвар түр алдахын өмнөх шимтгэл төлсөн нийт цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг шимтгэл төлсөн сарын тоонд хувааж

1 сараас доош хугацаанд ажиллаж байхдаа хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол



Ажилд томилсон шийдвэрээр тогтоосон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээгээр

ᠶᠡᠯᠳᠦᠪᠦᠷᠯᠡᠯᠢᠢᠨ ᠣᠰᠣᠯ, ᠮᠡᠷᠭᠡᠵᠯᠡᠰ ᠰᠢᠯᠲᠭᠠᠯᠰᠠᠨ Өᠦᠪᠴᠢᠨ ᠤᠯᠮᠠᠰ ᠳᠠᠭᠲᠤᠭᠤᠯᠠᠭᠴᠢ ᠨᠠᠰ ᠪᠠᠷᠰᠠᠨ ᠲᠣᠬᠢᠣᠯᠳᠣᠯᠳ ᠲᠦᠭᠦᠨᠢ ᠭᠡᠷ ᠪᠦᠯᠢᠶᠢᠨ ᠭᠢᠰᠢᠭᠦᠨᠳ ᠲᠡᠭᠲᠡᠮᠵᠢ ᠣᠯᠭᠢᠨᠢ.

НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ОЛГОХ ТЭТГЭМЖ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагч нас барсан тохиолдолд түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно.



Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээ 2.000.000 төгрөг бөгөөд хэрэв нас барсан даатгуулагч амьгүй донор болж эс, эд эрхтнээ бусдад шилжүүлсэн бол 3.500.000 төгрөгийн тэтгэмжийг нэг удаа олгоно.

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР АВАГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ТӨЛБӨР

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон авч байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн төлбөрийг түүний хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаанд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлнө.

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗАРДЛЫН ТӨЛБӨР

Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан бол дараах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг олгоно.



Хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон протез, ортпепийн зардлын төлбөр

3 жил тутамд нэг удаа

Сэргээн засах болон сувилалын тусламж, үйлчилгээний төлбөр

Нэг ор хоногт 70,000 төгрөг

Сэргээн засах төв болон сувилалд ирэх буцах унааны зардлын төлбөр

Галт тэрэг, хөм хоорондын нийтийн тээврийн тухайн үед мөрдөж байгаа үнээр

ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САН

Тэтгэврийн хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байна.



Ажил олгогчийн болон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийн тус тус 1%, нийт 2%-ийн, сайн дурын даатгуулагчийн төлсөн 2%-ийн шимтгэлийн орлого

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу улсын төсөвт шилжүүлсэн орлогоос Засгийн газрын тогтоосон хэмжээгээр

Улсын төсвөөс олгох бусад орлого

Тэтгэврийн нөөц санд байршуулсан даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогыг түүний саналд үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан санхүүгийн хэрэгсэлд болон тухайлсан хуулиар зохицуулсан эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтэд хөрөнгө оруулж болно.

ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САНД БҮРДСЭН МӨНГӨЖҮҮЛСЭН ОРЛОГООС ЭВЛҮҮЛЭХ

1
2
3

1 Даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүнд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоож олгоно.

2 Хэрэв тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байсан гэр бүлийн гишүүн 19 нас хүрсэн, хөдөлмөрийн чадвар нь сэргээгдсэн, нас барсан бол мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт олгосон тэтгэврийн хэмжээний зөрүүг тогтоож хууль ёсны өв залгамжлагчид өвлүүлнэ.

3 Хэрэв гэр бүлийн гишүүнд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхгүй бол тэтгэврийн нөөц санд бүрдсэн мөнгөжүүлсэн орлогын тодорхой хувийг хууль ёсны өв залгамжлагчид өвлүүлнэ.

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ОЛОН УЛСЫН ХЭЛЭЛЦЭЭРҮҮД



БНМАУ, ЭСБНХУ-ын хооронд байгуулсан
“Нийгэм хангамжийн салбарт хамтран
ажиллах тухай хэлэлцээр”



1981.04.06-ны өдөр “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг байгуулсан.

Хэлэлцээрийн үндсэн агуулга:

Даатгуулагч Монгол Улс болон Оросын Холбооны Улсад шимтгэл төлж ажилласан хугацаагаа нэгтгэн тооцуулж, хэлэлцэн тохирогч аль нэг талын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоолгох харилцааг зохицуулсан.

Жишээ:

Монгол Улсын Иргэн “Г” нь 15 жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд Оросын Холбооны Улсад 20 жил ажиллаж амьдрахдаа Оросын Холбооны Улсын тэтгэврийн даатгалд мөн хамрагдсан гэвэл:

- Иргэн “Г”-ийн Оросын Холбооны Улсад болон Монгол Улсад шимтгэл төлж ажилласан жилийг нэгтгэн нийт 35 жил (15 жил+20 жил) ажилласнаар тооцно. Тэрээр Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Оросын Холбооны Улсад тэтгэвэр тогтоолгох бол Оросын Холбооны Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу өндөр насны тэтгэврээ тогтоолгоно.



Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд байгуулсан
“Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр”



Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээрийг 2006 оны 5 дугаар сарын 8-ны өдөр байгуулж хоёр Улсын Их Хурлаар соёрхон баталснаар 2007 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Хэлэлцээрийн үндсэн агуулга:

Хоёр улсын иргэдийг тэтгэврийн даатгалд давхар даатгуулахгүйгээр өөрийн улсын тэтгэврийн даатгалд даатгуулах, хэрэв давхар даатгуулсан тохиолдолд Солонгос Улсын Үндэсний тэтгэврийн албанд төлсөн шимтгэлийг нь буцаан олгох явдал юм. Энэхүү хэлэлцээрээр БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэд өөрийн орны тэтгэврийн даатгалд хамрагдаж, ирээдүйн нийгмийн баталгаагаа хангах, тэтгэврийн даатгалын шимтгэлийг БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд давхар төлөхгүй, БНСУ-ын хуулийн дагуу заавал хамрагдах тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх боломж бүрдсэн.

Жишээ:

Иргэн “А” нь нийтдээ 15 жил нийгмийн даатгалын шимтгэл төлж ажиллаж байгаад БНСУ-д 8 жил хөдөлмөрийн гэрээгээр ажилласан. Тэрээр уг хугацаанд сар бүр 50,000 воныг Монгол Улсын тэтгэврийн даатгалын санд төлсөн гэвэл:

- “А” нь хэлэлцээрийн дагуу БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд төлөх шимтгэлээс чөлөөлөгдөн сар бүр өөрийн орны тэтгэврийн даатгалд хамрагдсан тул тэтгэврийн насанд хүрээд нийтдээ 23 жил (15 жил + 8 жил) шимтгэл төлж ажилласнаар өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй болно.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023.12.04-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийн сард төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг 50,000 оноор тогтоосон.



Монгол Улс, Бүгд Найрамдах Унгар Улсын
хооронд байгуулсан
“Нийгмийн хамгааллын хэлэлцээр”



Монгол Улс болон Бүгд Найрамдах Унгар Улсын хоорондын Нийгмийн хамгааллын хэлэлцээрийг 2011 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Будапешт хотноо үйлдэж улмаар хоёр тал соёрхон баталснаар 2012 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.

Хэлэлцээрийн үндсэн агуулга:

Даатгуулагч Монгол Улс болон Унгар Улсад шимтгэл төлж ажилласан хугацаагаа нэгтгэн тооцуулж хэлэлцэн тохирогч аль нэг талын хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох харилцааг зохицуулсан. Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Унгар Улсад тэтгэвэр тогтоолгох бол Унгар Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоолгоно.

Жишээ:

Монгол Улсын иргэн “Д” 60 настай, тэтгэврийн даатгалын санд 18 жил шимтгэл төлсөн, Унгар Улсад 15 жил ажиллахдаа Унгар Улсын тэтгэврийн даатгалд хамрагдаж шимтгэл төлсөн, тэтгэвэр тогтоох цалингийн дундаж нь 950.000₮ гэвэл түүнд олгох тэтгэврийг тооцож үзье.

- а. Нэгтгэн тооцсон хугацаа: 33 жил (Монгол Улсад 18 жил, Унгар Улсад 15 жил)
- б. Тэтгэвэр бодох хувь - 64.5% (20 жил 45% + 13 жил * 1.5%)
- в. 33 жилд ногдох тэтгэвэр: $950,000₮ * 64.5\% = 612,750₮$
- г. Монгол Улсад шимтгэл төлсөн 18 жилийн эзлэх хувь: 54.55% (18 жил : 33 жил * 100)
- д. 18 жилд ногдох тэтгэвэр: $334,255₮ (612,750₮ * 54.55\%)$

“Д”-д Монгол Улсын тэтгэврийн даатгалын сангаас сар бүр 334,255₮-ийн тэтгэвэр олгоно.

Унгар Улсын хуулиар өндөр насны тэтгэврийн нас 65, шимтгэл төлбөл зохих хугацааны доод хязгаар 20 жил (хувь тэнцүүлсэн тэтгэврийн тухайд 15 жил) байдаг тул “Д” нь 63.6 нас хүрээд Унгар Улсын талд өргөдлөө гарган Унгар Улсад ажиллаж шимтгэл төлсөн цалин хөлснөөсөө 33 жилээр тэтгэвэр бодуулж, үүнээс тус улсад шимтгэл төлсөн 15 жилд ногдох тэтгэврийг Унгар Улсын тэтгэврийн сангаас сар бүр авна.



Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын
хооронд байгуулсан
“Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр”



Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улсын хоорондын Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Прага хотноо гарын үсэг зурснаар 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.

Хэлэлцээрийн үндсэн агуулга:

Даатгуулагч Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улсад шимтгэл төлж ажилласан давхцаагүй хугацаагаа нэгтгэн тооцуулж аль нэг талын хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох бол энэ асуудлыг хариуцсан хоёр улсын байгууллагад өргөдөл гарган хугацаагаа нэгтгэн тооцуулж тэтгэвэр тогтоолгох боломжтой. Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Чех Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Чех Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

Жишээ:

Монгол Улсын Иргэн “Б” нь 60 настай, Монгол Улсын нийгмийн даатгалд 14 жил шимтгэл төлсөн, Бүгд Найрамдах Чех Улсад 21 жил ажиллаж, амьдрахдаа БНЧУ-ын тэтгэврийн даатгалд мөн хамрагдсан гэвэл:

- Иргэн “Б” нь Бүгд Найрамдах Чех Улс болон Монгол Улсад шимтгэл төлсөн жилээ нэгтгэн нийт 35 жил болгон тооцуулж, хоёр орноос тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ.
- Иргэн “Б” Монгол Улсын хуулийн дагуу тэтгэврийн насанд хүрсэн тул тэтгэврээ тогтоолгож болно. “Б”-ийн 35 жил шимтгэл төлсөн хугацаанд авах тэтгэврийг Монгол Улсад авч байсан цалин хөлснөөс нь бодож, түүнээсээ 14 жилд ногдох хэсгийг Монголын Улсын тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгоно.
- Бүгд Найрамдах Чех Улсын хуулиар өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх нас нь эмэгтэй 61 нас 4 сар - 64 нас 4 сар, эрэгтэй 64 нас 4 сар, тэтгэвэр тогтоох шимтгэл төлж ажилласан хугацааны доод хязгаар нь 35 жил байдаг бөгөөд иргэн “Б” уг нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд Чех Улсын талаас тус улсад шимтгэл төлсөн 21 жилд ногдох хугацааны тэтгэвэр тогтоолгох боломжтой.



Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улсын
хооронд байгуулсан
“Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр”



Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улс хоорондын нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурлаар соёрхон баталснаар 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Хэлэлцээрийн үндсэн агуулга:

Хоёр улсад тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцож, тэтгэвэр болон оршуулгын тэтгэмж тогтоох, олгох, тэтгэврийг харилцан шилжүүлэх, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэмжүүдийг тогтоолгох боломжтой. Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Польш Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Польш Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

Жишээ:

Монгол Улсын Иргэн “Г” 60 настай, Монгол Улсын нийгмийн даатгалд 17 жил шимтгэл төлсөн, Бүгд Найрамдах Польш Улсад 10 жил ажиллаж, амьдрахдаа Польш Улсын тэтгэврийн даатгалд мөн хамрагдсан гэвэл:

- Иргэн “Г” нь Бүгд Найрамдах Польш Улс болон Монгол Улсад шимтгэл төлсөн жилээ нэгтгэн нийт 27 жил болгон тооцуулж, хоёр орноос тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ.
- Иргэн “Г” Монгол Улсын хуулийн дагуу тэтгэврийн насанд хүрсэн тул тэтгэврээ тогтоолгож болно. “Д”-ийн 27 жил шимтгэл төлсөн хугацаанд авах тэтгэврийг Монгол Улсад авч байсан цалин хөлснөөс нь бодож, түүнээсээ 17 жилд ногдох хэсгийг Монголын Улсын тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгоно.
- Бүгд Найрамдах Польш Улсын хуулиар өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх нас нь эмэгтэй 60 нас, эрэгтэй 65 нас, тэтгэвэр тогтоох шимтгэл төлж ажилласан хугацааны доод хязгаар нь эмэгтэй 20 жил, эрэгтэй 25 жил байдаг бөгөөд иргэн “Г” уг нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд Польш Улсын талаас тус улсад шимтгэл төлсөн 10 жилд ногдох хугацааны тэтгэвэр тогтоолгох боломжтой.



Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын
хооронд байгуулсан
“Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр”



Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улс хоорондын нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрт 2018 оны 3 дугаар сарын 07-ны өдөр гарын үсэг зурж, Улсын Их Хурлаар 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр соёрхон баталснаар 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Хэлэлцээрийн үндсэн агуулга:

Монгол Улс болон Бүгд Найрамдах Турк Улсад шимтгэл төлсөн, төлж байгаа бүх иргэд хамаарах ба хоёр улсад тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр болон оршуулгын тэтгэмж тогтоох, олгох, тэтгэврийг харилцан шилжүүлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр олгох явдал юм. Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Турк Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Турк Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

Жишээ:

Монгол Улсын Иргэн “С” нь 14 жил Монгол Улсад нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, тэрээр Бүгд Найрамдах Турк Улсад 21 жил ажиллаж, амьдрахдаа Бүгд Найрамдах Турк Улсын тэтгэврийн даатгалд мөн хамрагдсан гэвэл:

- Иргэн “С” нь Бүгд Найрамдах Турк Улс болон Монгол Улсад шимтгэл төлсөн жилээ нэгтгэн нийт 35 жил болгон тооцуулж, хоёр орноос тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ.
- Иргэн “С” нь тэтгэврийн нас болон шимтгэл төлсөн хугацааны аль алины хувьд Монгол Улсын хуульд заасан нөхцөлийг хангаж байгаа тул өргөдлөө гаргаж Монгол Улсад өндөр насны тэтгэврээ эхлээд тогтоолгоно. “С”-ийн 35 жил шимтгэл төлсөн хугацаанд авах тэтгэврийг Монгол Улсад авч байсан цалин хөлснөөс нь бодож, түүнээсээ 14 жилд ногдох хэсгийг Монгол Улсын тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгоно.
- Бүгд Найрамдах Турк Улсын хуулиар өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас эмэгтэй 58, эрэгтэй 60, шимтгэл төлсөн байвал зохих хугацааны доод хязгаар 20 жил байдаг бөгөөд иргэн “С” уг нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд Турк Улсын талаас тус улсад шимтгэл төлсөн жилд ногдох хугацааны тэтгэвэр тогтоолгох боломжтой.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТӨӨ
ХЯНАХ, ТОДОРХОЙЛОЛТ, ЛАВЛАГАА АВАХ ЗААВАР

1. Цахим хуудсаар:

Нийгмийн даатгалын байгууллагын www.ndaatgal.mn цахим хуудас дахь “Цахим үйлчилгээ” цонхоор нэвтрэн “Иргэн”-ээр орж “Лавлагаа, тодорхойлолт” цэсээс авах;

2. Гар утсаар:

“Нийгмийн даатгал аппликейшн” татаж авах;

- IOS системийн гар утастай бол App store программаас
- Andriod системийн утастай бол Play store программаас



3. Төрийн үйлчилгээний:

- www.e-mongolia.mn
- E-Mongolia аппликейшн системээс;

4. Төрийн үйлчилгээний ТҮЦ

машинаас авах;

“НИЙГМИЙН ДААТГАЛ” ГАР УТАСНЫ АППЛИКЕЙШН АШИГЛАХ ЗААВАР



Та “НИЙГМИЙН ДААТГАЛ” аппликейшнийг ашиглан дараах үйлчилгээг авах боломжтой:

- Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн мэдээллээ жил, сараар нь харах, хянах, хэвлэж авах
- Нийгмийн даатгалын байгууллагаас авсан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн мэдээллээ харах
- Сайн дурын даатгалын гэрээгээ цахимаар байгуулах, сунгах
- Сайн дурын даатгалын шимтгэлээ төлөх
- Тэтгэврийн нөөц санд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн талаар мэдээлэл авах
- Нийгмийн даатгалын талаарх цаг үеийн мэдээ, мэдээлэл авах
- Санал хүсэлтээ цахимаар илгээж шийдвэрлүүлэх

“Нийгмийн даатгал” аппликейшний бүтэц

НДШ төлөлтийн лавлагаа

- НДШ шимтгэл төлөлтийн мэдээллээ он, сараар нь нарийвчлан харах
- НДШ төлөлтийн лавлагаа авах
- НДШ төлөлтийн лавлагаа авсан түүхээ харах боломжтой

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2006 оноос хойшхи бүх мэдээлэл харагдана.

Сайн дурын даатгалын гэрээ байгуулах

- Энгийн сайн дурын даатгалын гэрээ
- 3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн сайн дурын даатгалын гэрээ
- 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх (эцэг)-ийн сайн дурын даатгалын гэрээ
- Малчин, туслах малчны сайн дурын даатгалын гэрээ

Сайн дурын даатгалын шимтгэл төлөх

Тэтгэмж авах хүсэлт

- Ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлт
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хүсэлт
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хүсэлт
- ҮОМШӨ Хөдөлмөрийн чадвараа түр алдсан тэтгэмжийн хүсэлт

Хүсэлтийн түүх



"Нийгмийн даатгал" аппликейшнийг гар утсандаа татах, баталгаажуулах



Нийгмийн даатгал



Даатгуулагч та iOS /iPhone/ болон Android системийн гар утас, ухаалаг төхөөрөмж хэрэглэдэг бол Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний аппликейшнийг ашиглан нийгмийн даатгалтай холбоотой мэдээ, мэдээллийг авах боломжтой.

- iPhone утастай бол "App Store"-д, Android утастай бол "Play Store"-д нэвтэрнэ.
- Search цэснээс "ndaatgal" эсхүл "Нийгмийн даатгал" гэж бичин хайж, утсандаа суулгана.

1. "Бүртгүүлэх" хэсэгт нэвтэрч регистрийн дугаар, утасны дугаар цахим шуудангийн хаягаа үнэн зөв оруулан бүртгүүлэх товчийг дарна.
(Зөвхөн өөрийн цахим шуудангийн хаягийг оруулах бөгөөд бусад хэрэглэгчтэй давхардсан тохиолдолд бүртгэх боломжгүй)

Санамж Хэрэв "...регистрийн дугаартай иргэний имэйл Нийгмийн даатгалын систем дээрх бүртгэлээс зөрж байна" гэсэн алдаа гарсан бол та нийгмийн даатгалын системд өмнө нь өөр имэйл хаяг бүртгүүлсэн байна гэсэн үг бөгөөд энэ тохиолдолд "ДАН" системээр нэвтэрч имэйл хаягаа солих, эсхүл Нийгмийн даатгалын газарт хандаарай.

2. Бүртгүүлсэн цахим шуудангийн хаяг (имэйл)-аар баталгаажуулах 6 оронтой код очно.
(Ирээгүй бол *spam, junk хавтас дотор шалгана*)

3. Баталгаажуулах 6 оронтой кодыг оруулж баталгаажуулах дээр дарна.

Санамж Та ямар нэг шалтгааны улмаас имэйлээр ирсэн 6 оронтой баталгаажуулах кодыг оруулалгүй апп-ыг хаагаад, дахин бүртгүүлэхэд "Хэрэглэгч бүртгэлтэй байгаа тул та мэдээллээ нягтлан дахин оролдоно уу" гэсэн алдаа гарсан бол нүүр хуудасруу буцаж нууц үг сэргээх үйлдэл хийнэ.

4. Хэрэв Та имэйл хаяг ашигладаггүй бол "ДАН" систем ашиглан нэвтрэх боломжтой.

САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ ЦАХИМААР БАЙГУУЛАХ


“Нийгмийн даатгал” аппликейшнээр сайн дурын даатгалын гэрээ байгуулах



“СДД-ын гэрээ байгуулах” цэсрүү орно.



- Сайн дурын даатгуулагчийн төрлөө сонгон хүсэлт гаргах товчийг дарна
- “Дэлгэрэнгүй” цэсээр орж мэдээлэл авах боломжтой



Хүүхдийн төрсний гэрчилгээ эсхүл гадаадад төрсөн хүүхдийг батлах баримтыг хавсаргана

Хүүхдийн төрсний гэрчилгээ, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тодорхойлолтыг хавсаргана

Гэрээ байгуулахын өмнөх жилийн мал, тэжээвэр амьтад, малын хашаа, худгийн тооллогын маягт буюу мал тооллогын “А” данс, Хэрэв туслах малчин бол малчинтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг хавсаргана



Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас таны мэдээлэл татагдан орсон байх бөгөөд та өөрийн ажил мэргэжил, утасны дугаар, цахим шуудан, гэрээний хугацаа, шимтгэл төлөх сарын орлогын хэмжээ гэсэн хэсгийг бөглөж үргэлжлүүлэх товч дарна.

ДААТГУУЛАГЧИД ЗОРИУЛСАН ВЭБЭЭР САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

АЛХАМ 1.

portal.ndaatgal.mn вэб сайтруу орж нэвтрэх товчийг дарна.

“ДАН” системийн эрхээр (нэг удаагийн нууц код, тоон гарын үсэг, банкны эрхээр) нэвтрэнэ.



АЛХАМ 2.

Доорх цонхны “зөвшөөрөх” товчийг дарснаар нийгмийн даатгал дахь өөрийн бүртгэл рүү орно.

Миний профайлууд гэсэн цонх харагдах ба өөрийн бүртгэл дээр дарж орно.



АЛХАМ 3.

Цахим үйлчилгээ авах → сайн дурын даатгал → даатгуулагчийн төрлийг сонгоод (энгийн, малчин, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх/эцэг гэх мэт) “**хүсэлт гаргах**” товчийг дарна.



АЛХАМ 4.

Гэрээ байгуулах ерөнхий мэдээлэл оруулах хэсгийг бүрэн гүйцэд бөглөж, мэдээллээ үнэн зөв оруулсан эсэхээ нягтална.

АЛХАМ 5.

“Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ”-тэй сайтар танилцаж гэрээний нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч байвал “**үргэлжлүүлэх**” товчийг дарснаар таны хүсэлт Нийгмийн даатгалын байгууллагад илгээгдэх бөгөөд тухайн сарын шимтгэлээ төлснөөр таны гэрээ хүчин төгөлдөр болж баталгаажна.

САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨХ ЗААВАР

АЛХАМ 1.

Төлбөр төлөх товч дээр дарна эсвэл Профайл → Хүсэлтийн түүх дээр дарж орно.



АЛХАМ 2.

Шимтгэл төлөх саруудыг сонгож “үргэлжлүүлэх” товчийг дарна.



АЛХАМ 3.

Төлбөр төлөх банкаа сонгосноор танд “QR” код харагдах бөгөөд уг кодыг уншуулж төлбөр төлөх үйлдлийг амжилттай хийснээр таны төлбөр баталгаажих болно.



ЦАХИМААР ТЭТГЭМЖИЙН ХҮСЭЛТ ГАРГАХ ЗААВАР (ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ БОЛОН ЖИРЭМЭН, АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ)

АЛХАМ 1.

portal.ndaatgal.mn вэб сайтруу орж нэвтрэх товчийг дарна.

"ДАН" системийн эрхээр (нэг удаагийн нууц код, тоон гарын үсэг, банкны эрхээр) нэвтэрнэ.



АЛХАМ 2.

Доорх цонхны "зөвшөөрөх" товчийг дарснаар нийгмийн даатгал дахь өөрийн бүртгэл рүү орно.

Миний профайлууд гэсэн цонх харагдах ба өөрийн бүртгэл дээр дарж орно.



АЛХАМ 3.

Даатгуулагч "цахим үйлчилгээ авах" цэснээс эмнэлгийн хуудас бичигдсэн тэтгэмж (хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж эсхүл жирэмсний болон амаржсаны тэтгэмж)-ийн төрлийг сонгон "хүсэлт гаргах" товчийг дарна.



АЛХАМ 4.

Дэлгэцэнд эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудасны мэдээлэл харагдах ба "тэтгэмж авагчийн үндсэн мэдээлэл" хэсгийн хоосон талбаруудыг бүрэн гүйцэд бөглөнө. Цоожтой талбаруудыг автоматаар бөглөсөн байх тул гараас өөчлөх боломжгүй. Мэдээллээ үнэн зөв оруулсан эсэхээ нягтлан "үргэлжлүүлэх" товчийг дарснаар таны хүсэлт Нийгмийн даатгалын байгууллага руу илгээгдэнэ.

АЛХАМ 5. Хүсэлтийн түүхээ шалгах

- Өөрийн профайл → хүсэлтийн түүх дээр дарж ороход таны илгээсэн хүсэлтүүд харагдана.
- Хүсэлтийн дугаар дээр дарснаар таны хүсэлт аль алхам дээр шалгагдаж байгааг харж болно.
- Нийгмийн даатгалын газрын хяналтын байцаагч баталгаажуулснаар таны хүсэлт "шийдэгдсэн" төлөвт орох бөгөөд "хүсэлтийн дугаар" дээр дарж орсноор танд олгох "тэтгэмжийн хэмжээ" харагдана.

ЦАХИМААР АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ХҮСЭЛТ ГАРГАХ ЗААВАР

АЛХАМ 1.

portal.ndaatgal.mn вэб сайтруу орж нэвтрэх товчийг дарна.

“ДАН” системийн эрхээр (нэг удаагийн нууц код, тоон гарын үсэг, банкны эрхээр) нэвтрэнэ.



АЛХАМ 2.

Доорх цонхны **“зөвшөөрөх”** товчийг дарснаар нийгмийн даатгал дахь өөрийн бүртгэл рүү орно.

Миний профайлууд гэсэн цонх харагдах ба өөрийн бүртгэл дээр дарж орно.



АЛХАМ 3.

- Даатгуулагч **“цахим үйлчилгээ авах”** → **“ажилгүйдлийн тэтгэмж”** цэсийг сонгоно.
- Дэлгэцэнд Хөдөлмөр, халамж үйлчилгээний байгууллагад бүртгүүлсэн талаарх мэдээллийг харуулна. Хэрэв бүртгүүлээгүй бол **ejob.gov.mn** хаягаар нэвтрэн ажилгүй болсноо бүртгүүлнэ.
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний байгууллагад бүртгүүлсний дараа **“Хүсэлт гаргах”** товчийг дарна.



АЛХАМ 4.

Нотлох баримт хавсаргах хэсэгт ажлаас чөлөөлсөн тухай шийдвэрийг заавал хавсаргах шаардлагатай. (Тооцоо нийлсэн, ажил хүлээлцсэн акт байгаа тохиолдолд мөн хавсаргана) **“Үргэлжлүүлэх”** товчийг даран дараагийн цонх руу шилжинэ.



АЛБАН ЖУРМЫН БОЛОН САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨХ ДАНСНЫ ДУГААР

Архангай аймаг

Төрийн банк	MN 95 0034 180000019632
Хаан банк	MN 96 000500 5135055961

Баян-Өлгий аймаг

Төрийн банк	MN 60 0034 291400007046
Хаан банк	MN 66 000500 5180028126
Голомт банк	MN 55 001500 5805001346
Капитрон банк	MN 49 003000 3005005300

Баянхонгор аймаг

Төрийн банк	MN 66 0034 230000030094
Хаан банк	MN 69 000500 5246025611
Голомт банк	MN 66 0015006 100000749
Худалдаа хөгжлийн банк	MN 44 0004000 445005000
Хас банк	MN 46 003200 5001360217

Булган аймаг

Төрийн банк	MN 97 0034 120000032694
Хаан банк	MN 57 000500 5270260598

Говь-Алтай аймаг

Төрийн банк	MN 12 0034 240000028398
Хаан банк	MN 51 000500 5315059962

Говьсүмбэр аймаг

Төрийн банк	MN 46 0034 300000020314
Хаан банк	MN 52 000500 5990039294

Дархан-Уул аймаг

Төрийн банк	MN 61 0034 140800001459
Хаан банк	MN 08 000500 5045001096
Капитрон банк	MN 33 003000 3006013806
Худалдаа хөгжлийн банк	MN 53 0004000 403011889
Голомт банк	MN 43 001500 4301035671

Дорноговь аймаг

Төрийн банк	MN 70 0034 281500002760
Хаан банк	MN 95 000500 5360093942
Капитрон банк	MN 86 003000 3021000807
Хас банк	MN 31 003200 5000016940
Голомт банк	MN 33 001500 5401009061
Худалдаа хөгжлийн банк	MN 89 0004000 408015471

Дорнод аймаг

Төрийн банк	MN 84 0034 260000029720
Хаан банк	MN 90 000500 5405177789
Хас банк	MN 21 003200 5000158740
Голомт банк	MN 96 001500 4701003062
Худалдаа хөгжлийн банк	MN 09 0004000 401065891

Дундговь аймаг

Төрийн банк	MN 87 0034 220000038204
Хаан банк	MN 52 000500 5450099464

Завхан аймаг

Төрийн банк	MN 80 0034 170000026256
Хаан банк	MN 15 000500 5495008996

Орхон аймаг

Төрийн банк	MN 75 0034 240501939408
Хаан банк	MN 54 000500 5090092658
Голомт банк	MN 70 001500 4001028735
Капитрон банк	MN 17 003000 300700473
Худалдаа хөгжлийн банк	MN 59 0004000 407025059

Өвөрхангай аймаг

Төрийн банк	MN 46 0034 190000343863
Хаан банк	MN 52 000500 5540021665

Өмнөговь аймаг

Төрийн банк	MN 02 0034 210000020189
Хаан банк	MN 45 000500 5585080619
Хас банк	MN 50 003200 5000537488
Голомт банк	MN 72 001500 5205009577
Капитрон банк	MN 45 003000 3017003108
Худалдаа хөгжлийн банк	MN 02 0004000 414005235

Сүхбаатар аймаг

Төрийн банк	MN 21 0034 270000130618
Хаан банк	MN 36 000500 5630082185
Хас банк	MN 04 003200 5000166224
Голомт банк	MN 45 001500 5900000513

Сэлэнгэ аймаг

Төрийн банк	MN 73 0034 151700031311
Хаан банк	MN 72 000500 5675357548
Голомт банк	MN 58 001500 4325105272
Худалдаа хөгжлийн банк	MN 08 0004000 469005097

Төв аймаг

Төрийн банк	MN 96 0034 310000059814
Хаан банк	MN 77 000500 5721100330

Увс аймаг

Төрийн банк	MN 97 0034 162000002748
Хаан банк	MN 05 000500 5800202604
Хас банк	MN 42 003200 5000173979
Голомт банк	MN 77 001500 6200000567

Ховд аймаг

Төрийн банк	MN 77 0034 110000035625
Хаан банк	MN 65 000500 5845138908
Голомт банк	MN 28 001500 5601001035
Хас банк	MN 38 003200 5000170559

Хөвсгөл аймаг

Төрийн банк	MN 58 0034 200000173460
Хаан банк	MN 71 000500 5890136712
Голомт банк	MN 67 001500 4901000803

Хэнтий аймаг

Төрийн банк	MN 28 0034 250000041253
Хаан банк	MN 34 000500 5935002012
Голомт банк	MN 12 001500 5505101012
Хас банк	MN 14 003200 5000031699

Сонгинохайрхан дүүрэг

Төрийн банк	MN 43 0034 103700002249
Хаан банк	MN 68 000500 5019261648
Голомт банк	MN 97 001500 2900000455
Худалдаа хөгжлийн банк	MN 37 0004000 468015369
Хас банк	MN 98 003200 5002062240

Сүхбаатар дүүрэг

Төрийн банк	MN 72 0034 103400014871
Хаан банк	MN 80 000500 5009126484
Голомт банк	MN 78 001500 1410008726
Капитрон банк	MN 78 003000 3020004567
Худалдаа хөгжлийн банк	MN 89 0004000 499135040

Хан-Уул дүүрэг

Төрийн банк	MN 05 0034 105400014166
Хаан банк	MN 96 000500 5022395214
Голомт банк	MN 24 001500 2105019063
Хас банк	MN 23 003200 5002356821
Капитрон банк	MN 93 003000 3008002681
Худалдаа хөгжлийн банк	MN 89 0004000 406005146

Чингэлтэй дүүрэг

Төрийн банк	MN 56 0034 102100001565
Хаан банк	MN 75 000500 5003440919
Голомт банк	MN 15 001500 8125100252
Капитрон банк	MN 30 003000 3039021020
Худалдаа хөгжлийн банк	MN 16 0004000 429001668

Багануур дүүрэг

Төрийн банк	MN 20 0034 330700001638
Хаан банк	MN 55 000500 5750180162
Голомт банк	MN 65 001500 4601029891
Хас банк	MN 54 003200 5000333425

Багахангай дүүрэг

Төрийн банк	MN 59 0034 300500011527
Хаан банк	MN 63 000500 5754001624

Баянгол дүүрэг

Төрийн банк	MN 98 0034 105100004490
Хаан банк	MN 49 000500 5034189999
Голомт банк	MN 36 001500 1805002406
Капитрон банк	MN 67 003000 3020010100
Худалдаа хөгжлийн банк	MN 04 0004000 499071483

Баянзүрх дүүрэг

Төрийн банк	MN 76 0034 105300001232
Хаан банк	MN 53 000500 5064063696
Голомт банк	MN 35 001500 1235100652
Капитрон банк	MN 69 003000 3022020001
Худалдаа хөгжлийн банк	MN 73 0004000 499071405

Налайх дүүрэг


Төрийн банк	MN 90 0034 312500527474
Хаан банк	MN 77 000500 5749024593
Хас банк	MN 95 003200 5000192425

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРУУДАЙ ХОЛБОО БАРИХ УТАС

Д/д	Хэлтсийн нэр	Утасны дугаар	И-мэйл хаяг	Фэйсбүүк хаяг
1	Багануур	70210021	baganuur@ndaatgal.mn	Багануур дүүргийн нийгмийн даатгалын газар
2	Багахангай	70491151	bagahangai@ndaatgal.mn	Багахангай дүүргийн нийгмийн даатгалын газар
3	Налайх	70232369	nalaih@ndaatgal.mn	Налайх дүүргийн нийгмийн даатгалын газар
4	Баянзүрх	75558484	bayanzurh@ndaatgal.mn	Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын газар
5	Баянгол	72001289	bayangol@ndaatgal.mn	Баянгол дүүргийн нийгмийн даатгалын газар
6	Сүхбаатар	70004300	sbdndaatgal@gmail.com	Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газар
7	Сонгино хайрхан	70175959	songinohairhan@ndaatgal.mn	Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын газар
8	Хан-Уул	75103030	han-uul@ndaatgal.mn	Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын газар
9	Чингэлтэй	70007790	chingeltei@ndaatgal.mn	Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын газар
10	Архангай	75079000	arhangai@ndaatgal.mn	Архангай аймгийн нийгмийн даатгалын газар
11	Баян-Өлгий	72022101	bayanulgii@ndaatgal.mn	Баян-Өлгий аймгийн нийгмийн даатгалын газар
12	Баянхонгор	70444475	bayanhongor@ndaatgal.mn	Баянхонгор аймгийн нийгмийн даатгалын газар
13	Булган	70342226	bulgan@ndaatgal.mn	Булган аймгийн нийгмийн даатгалын газар
14	Говь-Алтай	70484217	govialtai@ndaatgal.mn	Говь-Алтай аймгийн нийгмийн даатгалын газар

15	Говьсүмбэр	70541289	govisumber@ndaatgal.mn	Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын газар
16	Дархан-Уул	77057799	darhan@ndaatgal.mn	Дархан-Уул аймгийн нийгмийн даатгалын газар
17	Дорноговь	70523223	dornogovi@ndaatgal.mn	Дорноговь аймгийн нийгмийн даатгалын газар
18	Дорнод	70585955	dornod@ndaatgal.mn	Дорнод аймгийн нийгмийн даатгалын газар
19	Дундговь	70592309	dundgovi@ndaatgal.mn	Дундговь аймгийн нийгмийн даатгалын газар
20	Завхан	70463820	zavhan@ndaatgal.mn	Завхан аймгийн нийгмийн даатгалын газар
21	Орхон	75776699	orhon@ndaatgal.mn	Орхон аймгийн нийгмийн даатгалын газар
22	Өвөрхангай	70322136	uvurhangai@ndaatgal.mn	Өвөрхангай аймгийн нийгмийн даатгалын газар
23	Өмнөговь	70533356	umnugovi@ndaatgal.mn	Өмнөговь аймгийн нийгмийн даатгалын газар
24	Сүхбаатар	70518351	suhbaatar aimag.ndaatgal.mn	Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын газар
25	Сэлэнгэ	70363463	ndaatgal.selenge@gmail.com	Сэлэнгэ аймгийн нийгмийн даатгалын газар
26	Төв	70274004	tuv@ndaatgal.mn	Төв аймгийн нийгмийн даатгалын газар
27	Увс	70453425	ndaatgal.uv.gov.mn	Увс аймгийн нийгмийн даатгалын газар
28	Ховд	70431616	hovd@ndaatgal.mn	Ховд аймгийн нийгмийн даатгалын газар
29	Хөвсгөл	75091000	niigmiindaatgal@khs.gov.mn	Хөвсгөл аймгийн нийгмийн даатгалын газар
30	Хэнтий	70562212	hentii@ndaatgal.mn	Хэнтий аймгийн нийгмийн даатгалын газар

ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЦАХИМ СУВГУУД



- Нийгмийн даатгалын үйлчилгээний цахим систем
<https://portal.ndaatgal.mn/>
- Төрийн үйлчилгээний цахим систем
<https://e-mongolia.mn/>
- “Нийгмийн даатгал” гар утасны аппликейшн



ТЭТГЭВЭР АВАГЧ ТА ШИНЭЧЛЭГДСЭН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЛЭЭ

www.ndaatgal.mn

- 1 “ДААТГУУЛГАЧИД ЗОРИУЛСАН ВЕБ” цахим систем
- 2 E-mongolia цахим хуудасны “ТЭТГЭВЭР ТОГООЛТЫН ХУУДАС” цахим тус тус хэрэг боломжтой.

Таны мэдэлтэй зүүлт төлбөрсөж өгөдөг 24-ТЭ цахим даатгал төлбөрийн байрны